



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 5 дугаар сар

Ерөнхий тойм: Энэ оны эхний 5 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28%-иар буюу 1,580 сая ам.доллараар буурч 3,999 сая ам.доллар байв. Үүнд экспорт 39%-иар буюу 1,257 сая ам.доллараар, импорт 14%-иар буюу 323 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 934 сая ам.доллараар буурч 14 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 5 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	5,064	5,578	3,999	514	10%	(1,580)	-28%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	2,885	3,263	2,006	378	13%	(1,257)	-39%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	2,179	2,315	1,992	136	6%	(323)	-14%
Тэнцэл	1,865	1,137	1,492	(728)		356	31%	706	948	14	242	34%	(934)	-99%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 899 сая ам.доллараар буурч 124 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 58% буюу 2,327 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 15% буюу 583 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 10%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 37%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10%-иар буурсан бол өмнөх сараас 13%-иар өсч 1.973-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс муудахад зэсийн болон чулуун нүүрсний үнийн индекс буурснаар тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас сайжрахад чулуун нүүрсний экспортын үнийн өсөлт болон нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ буурснаас голлон шалтгаалжээ.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2020 оны эхний 5 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 39%-иар буюу 1,257 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 32 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 4 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
1. Уул уурхай		2,571	89%		2,932	90%		1,881	94%		361	14%	13%	(1,051)	-36%	-32%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	601	823	29%	624	893	27%	556	614	31%	70	8%	2%	(279)	-31%	-9%	
1.2. Чулуун нүүрс	14,114	1,104	38%	15,061	1,272	39%	6,291	513	26%	168	15%	6%	(759)	-60%	-23%	
1.3. Боловсруулаагүй нефть	2,766	177	6%	2,628	150	5%	664	25	1%	(27)	-15%	-1%	(125)	-84%	-4%	
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,768	131	5%	3,489	207	6%	3,449	235	12%	76	58%	3%	27	13%	1%	
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	5%	4,665	196	6%	4,918	266	13%	51	36%	2%	70	36%	2%	
1.6. Цайрын хүдэр, баяжмал	52	93	3%	65	96	3%	58	71	4%	3	3%	0%	(25)	-26%	-1%	
1.7. Жонош, лейцит, нефелин	153	51	2%	221	75	2%	237	60	3%	24	48%	1%	(14)	-19%	0%	
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	18	1%	2	20	1%	3	18	1%	2	11%	0%	(3)	-13%	0%	
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	2	0%	0	2	0%	0	0	0%	0	1%	0%	(2)	-98%	0%	
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	-	0%	79,390	49	2%	(0)	0%	0%	49	0%	1%	
1.11. Бусад	211	27	1%	75	21	1%	28	31	2%	(6)	-23%	0%	10	47%	0%	
2. Мал аж, ахуй	209	191	7%	184	224	7%	132	62	3%	33	17%	1%	(162)	-72%	-5%	
2.1. Амьд мал, малын мах	9	20	1%	11	21	1%	1	2	0%	0	1%	0%	(19)	-91%	-1%	
2.2. Арьс, шир	191	11	0%	161	8	0%	126	6	0%	(2)	-23%	0%	(3)	-32%	0%	
2.3. Малын өлөн гэдэс	0	3	0%	0	4	0%	0	4	0%	1	32%	0%	0	0%	0%	
2.4. Ноолуур	5	151	5%	5	181	6%	3	47	2%	30	20%	1%	(134)	-74%	-4%	
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	5	0%	5	9	0%	3	3	0%	4	79%	0%	(6)	-63%	0%	
2.6. Бусад	0	1	0%	2	1	0%	0	0	0%	(0)	-20%	0%	(0)	-13%	0%	
3. Газар тариалан	6	2	0%	22	5	0%	16	5	0%	4	205%	0%	(0)	-8%	0%	
4. Аж үйлдвэрлэл	132	121	4%	195	102	3%	113	58	3%	(19)	-16%	-1%	(44)	-43%	-1%	
4.1. Хүнс	10	30	1%	11	27	1%	2	6	0%	(3)	-11%	0%	(21)	-77%	-1%	
4.2. Ноолууран эдлэл	0	7	0%	0	11	0%	0	5	0%	4	60%	0%	(6)	-56%	0%	
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	5	0%	1	4	0%	2	4	0%	(1)	-11%	0%	(0)	-3%	0%	
4.4. Уул уурхай	15	46	2%	51	42	1%	9	29	1%	(3)	-7%	0%	(13)	-31%	0%	
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	15%	0%	(0)	-6%	0%	
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	31	1%	1	14	0%	1	12	1%	(17)	-54%	-1%	(3)	-18%	0%	
4.7. Бусад	104	2	0%	131	3	0%	98	2	0%	1	33%	0%	(1)	-40%	0%	
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-6%	0%	0	30%	0%	
Нийт дүн		2,885		3,263			2,006			378	13%		(1,257)	-39%		

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 5 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(1,004)		(47)		(1,051)	-36%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(76)	27%	(203)	73%	(279)	-31%
1.2. Чулуун нүүрс	(715)	94%	(44)	6%	(759)	-60%
1.3. Боловсруулаагүй нефть	(73)	58%	(52)	42%	(125)	-84%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(3)	-10%	30	110%	27	13%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(130)	-186%	200	286%	70	36%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(8)	32%	(17)	68%	(25)	-26%
1.7. Жонош, лейцит, нефелин	4	-28%	(18)	128%	(14)	-19%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	-62%	(4)	162%	(3)	-13%
1.11. Бусад	(53)	-540%	63	640%	10	47%
2. Мал аж, ахуй	(81)	50%	(81)	50%	(162)	-72%
2.1. Амьд мал, малын мах	(36)	193%	17	-93%	(19)	-91%
2.2. Арьс, шир	(2)	58%	(1)	42%	(3)	-32%
2.4. Ноолуур	(39)	29%	(96)	71%	(134)	-74%
3. Газар тариалан	(2)	419%	1	-319%	(0)	-8%
4. Аж үйлдвэрлэл	(154)	352%	110	-252%	(44)	-43%
5. Бусад	(0)	-108%	0	17%	0	30%
Нийт дүн	(1,241)		(16)		(1,257)	-39%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2020 оны эхний 5 сард уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 1,241 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 16 сая ам.доллараар буурлаа. Үүнээс чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 790 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 247 сая ам.доллараар тус тус буурав. Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалж 81 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан мөн 81 сая ам.доллараар буурсан.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 5 дугаар сард 1,719 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 34%-иар, өмнөх сараас 2%-иар өслөө. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,240; 94 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 13%-иар, төмрийн хүдэр 6%-иар буурсан, зэсийн үнэ өмнөх сараас 4%-иар, төмрийн хүдэр 11%-иар өслөө. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 5 дугаар сард 82 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3%-иар буурсан бол өмнөх сараас 1%-иар өслөө.

Импорт 2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14%-иар буюу 323 сая ам.доллараар буурав. Импортын 14 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 7 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 4 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	ДҮН	%	Тоо/хэм (мян нэгж)	ДҮН	%	Тоо/хэм (мян нэгж)	ДҮН	%	ДҮН	Өсөлт	% ²	ДҮН	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		591	27%	652	28%		573	29%		62	10%	3%	(79)	-12%	-3%
Түргэн эдлэгтэй	375	318	15%	340	326	14%	362	328	16%	8	2%	0%	2	1%	0%
Хүнс	175	221	10%	163	231	10%	172	229	11%	9	4%	0%	(2)	-1%	0%
Эм, тариа	1	42	2%	1	40	2%	1	44	2%	(2)	-5%	0%	4	1%	0%
Бусад түргэн эдлэгтэй бараа	199	54	3%	176	55	2%	189	54	3%	0	7%	0%	(1)	-1%	0%
Удаан эдлэгтэй	74	273	13%	139	327	14%	107	246	12%	54	20%	2%	(81)	-25%	-4%
Гутал, хувцас, цүнх	23	29	1%	29	27	1%	42	27	1%	(2)	-7%	0%	0	1%	0%
Гэр охуйн цах.хэрэгсэл ба тавилга	22	43	2%	79	42	2%	34	38	2%	(1)	-2%	0%	(4)	-9%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	171	8%	1	223	10%	1	147	7%	52	30%	2%	(76)	-34%	-3%
Бусад удаан эдлэгтэй бараа	28	31	1%	29	35	2%	31	33	2%	4	15%	0%	(2)	-5%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	678	896	41%	523	977	42%	576	822	41%	81	9%	4%	(154)	-16%	-7%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	10	570	26%	12	671	29%	13	530	27%	101	18%	5%	(141)	-21%	-6%
Сүүдлээс бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	193	9%	1	237	10%	4	168	8%	44	23%	2%	(69)	-29%	-3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	10	377	17%	11	434	19%	9	363	18%	57	15%	3%	(72)	-16%	-3%
Барилгын материал	264	238	11%	345	238	10%	421	222	11%	0	0%	0%	(16)	-7%	-1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	18	88	4%	10	67	3%	14	70	4%	(20)	-23%	-1%	3	5%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	578	303	14%	680	258	11%	634	269	13%	(45)	-15%	-2%	11	4%	0%
Хүнсний орц	232	62	3%	16	9	0%	109	27	1%	(53)	-86%	-2%	19	215%	1%
Химийн бүтээгдэхүүн	81	49	2%	80	45	2%	80	45	2%	(4)	-7%	0%	0	0%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	26	11	1%	34	12	1%	29	11	1%	1	10%	0%	(1)	-1%	0%
Цахилгаан эрчим хүч	1	59	3%	1	59	3%	1	59	3%	(1)	-1%	0%	1	1%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	1	0	0%	0	58%	0%	0	5%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	337	122	6%	391	133	6%	356	125	6%	11	9%	0%	(8)	-6%	0%
Нефтийн бүтээгдэхүүн	578	386	18%	680	426	18%	634	326	16%	40	10%	2%	(99)	-23%	-4%
Дизель түлш	322	207	9%	406	253	11%	333	169	8%	46	22%	2%	(84)	-33%	-4%
АИ-92, АИ-95	190	88	4%	191	111	5%	183	87	4%	22	25%	1%	(23)	-21%	-1%
А-80 болон бусад	125	90	4%	83	62	3%	119	70	4%	(28)	-31%	-1%	8	13%	0%
Бусад	11	4	0%	2	2	0%	100	2	0%	(1)	-36%	0%	(1)	-23%	0%
Нийт дүн		2,179		2,315			1,992			136	6%		(323)	-14%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 5 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	(40)	51%	(39)	49%	(79)	-12%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(40)	51%	(39)	49%	(79)	-12%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	95	-61%	(249)	161%	(154)	-16%
Аж үйлдвэрлэлийн орц	12		(1)		11	4%
Нефтийн бүтээгдэхүүн	(20)	20%	(79)	80%	(99)	-23%
Дизель түлш	(37)	44%	(47)	56%	(84)	-33%
АИ-92, АИ-95	(4)	16%	(20)	84%	(23)	-21%
А-80 болон бусад	21	254%	(13)	-154%	8	13%
Бусад	2		(2)		(1)	-23%
Нийт дүн	48	-15%	(370)	115%	(323)	-14%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 154 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 99 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 79 сая ам.доллараар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 11 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 323 сая ам.доллараар буурлаа.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 59 хувиар, өмнөх сараас 34 хувиар тус тус буурч тонн тутамд 275 ам.долларт хүрэв.